



Ц.Нарангэрэл
МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн
багш, магистр



Г.Отгонсүрэн
МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн
багш, магистр

КОМПЬЮТЕРТ СУУРИЛСАН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙН АСУУДАЛД

(Сонсох чадварыг бусад чадвартай шүтэлцүүлэн сургах
жишээн дээр)

Abstract: Many ESL/EFL professionals remain indifferent to the evolving role of computer assisted language learning (CALL) and recent learning theories based on neuroscientific studies. This study attempts to shed some lights in this area in the Mongolian context, particularly in the context of Teacher's school. This small-scaled, pilot and qualitative study seeks to identify the differences between classroom learning and computer-based learning of DynEd program and its impact on students' learning outcomes. The findings of this study reveals that computer-based learning approach had an effective impact on students' learning outcomes by allowing to transfer of skills from listening to speaking, reading, writing, and increase in vocabulary.

Key words: DynEd, Computer assisted language learning (CALL), Blended learning, transfer of skills, working memory, and long-term memory.

Орчин үед компьютерт суурилан гадаад хэлийг заах нь хэлний боловсролд их хүчтэй нэвтэрч байна. Lance Knowles (2004) суралцагчид зорилтот хэлийг шинэ арга замаар ялангуяа хэлний сургалтын гол цөм нь болох сонсох чадвар дээр суурилан сурах болсон нь том ололт юм гэж тэмдэглэжээ. Технологийн шинэ хэрэгслүүд нэвтэрснээр сурах бичигт суурилсан сургалтыг эвдэж, сонсох чадвартай уялдуулан бусад чадварыг хөгжүүлэх бодит боломж нээгдсэн. Ингэснээр гадаад хэл сурах RHR буюу олон удаа давтаж, шаталж, таньж мэдэх гэсэн Lance Knowles-ийн үндэслэсэн сонсох ярих чадварыг гол болгосон арга бүтээгдсэн байна. Энэ аргад суурилсан англи хэлийг компьютерээр заах асуудлыг шийдсэн нэг хөтөлбөр бол Dynamic Education буюу DynEd юм.

2013 оны 8-р сараас эхлэн Steppe Learning LLC, БШУЯ, МУБИС-ийн хамтарсан төслийн дагуу суралцагчдын бие даасан суралцахуйг дэмжих, зорилтот хэлээ хэрэглэж сурахад нь туслах зорилгоор компьютерт суурилсан англи хэлний DynEd хөтөлбөрийн сургалтыг МУБИС-ийн Багшийн сургуульд хэрэгжүүлж байна.

Судалгаа нь танхимын болон компьютерт суурилсан суралцахуй хоёрын ялгааг гарган, оюутнуудад яаж нөлөөлж байгааг харуулах зорилготой бөгөөд ялангуяа танхимын сургалтаас илүү компьютерт суурилсан сургалт нь суралцагчдын сонсох чадварыг илүү үр дүнтэй хөгжүүлж, сонсох чадвартай бусад чадвар шүтэлцэн сайжирч болдогийг харуулахыг хичээсэн болно.

Судлагдсан байдал

DynEd нь 20-иод жилийн түүхтэй бөгөөд 1990-ээд оны дунд үеэс Lance Knowles-ийн хөгжүүлсэн сонсох, ярих чадварыг голлосон RHR-ийн аргад суурилсан байдаг. Гэхдээ DynEd-ийн амжилт нь RHR-ийн аргад суралцсан туршлагатай багш нарын хэрэглэдэг "тархинд суурилсан холимог сургалтын загвар"-т тулгуурладаг. Энэ загвар нь 3 түлхүүр элементтэй:

- Бие дааж суралцах – DynEd-ийн өөрт тохирсон хичээлийг ганцаарчлан судлах

- Бататгах хичээл – танхимын сургалт
- Зөвлөгөө өгч, дасгалжуулах – ганцаарчлан буюу бүлгээрээ сурч байгаа суралцагчдын суралцахуйн тухай мэдээллийг DynEd-ийн мэдээллийн системээс харж, тухайн суралцагчдад мэдээлэн цаашид сайжруулах тухай зөвлөгөө өгөх

Суралцагч “ухаалаг” мультимедиа хичээлийг ашиглан бие даан суралцах үйлийг танхимын сургалттай хослуулах нь сургалтыг хамгийн сайн үр дүнд хүргэнэ. Суралцагчид хэлийг багшийн зааснаар биш, өөрсдөө эзэмших боломжтой бөгөөд DynEd хөтөлбөр нь суралцагчдад гадаад хэл сурах өөрийн гэсэн арга барилтай болох, хэрхэн суралцаж байгаадаа санал зөвлөгөө авах, яаж илүү их үр дүнтэй суралцах удирдамжаар хангагдах боломж олгодог. Багшийн үүрэг бол суралцагчдын бие даан суралцаж байгаа байдлыг байнга хянаж, үнэлгээ, хувь хүн бүрд үнэлгээ, зөвлөгөө өгч, удирдамжаар хангах явдал юм (Knowles, 2004).

DynEd хөтөлбөрийг Аргентин, Франц, Турк, Хятад, Монгол зэрэг хэд хэдэн орны Боловсролын яам зөвшөөрөн хэрэгжүүлж байна.

Бидний судалгаа нь компьютерт суурилсан сургалт ба танхимын сургалтаар хэлний чадварыг хөгжүүлэх ялгааг харуулахыг зорьсон чанарын судалгаа юм. Оюутнуудын суралцахуйн үр дүнд харуулахыг зориогүй, харин хосолмол сургалтын аргыг хэрэглэх нь тэдний суралцахуйн үр дүнд хэрхэн нөлөөлж болохыг гаргахыг зорьсон. Судалгаанд МУБИС-ийн Багшийн сургуулийн DynEd хөтөлбөрийг 128 цаг судалсан нэгдүгээр курсийн 78 оюутан оролцсон.

Суралцагчдын 1-р улирлын дүнд хийсэн анализ



№	Student Name	GEN PTL-1	GEN PTL-2	GEN PTL-DIF	Progress		Total
1	Student 187	0.0	0.7	0.7	3 level	3 level	2
2	Student 207	0.0	0.5	0.5	2 level	2 level	4
3	Student 227	0.0	0.2	0.2	1 level	1 level	10
4	Student 233	0.0	0.5	0.5	2 level	no changes	3
5	Student 239	0.0	0.0	0.0	no changes	top-down	
6	Student 286	0.0	0.2	0.2	1 level		
7	Student 313	0.0	0.5	0.5	2 level		
8	Student 314	0.0	0.7	0.7	3 level		
9	Student 324	0.0	0.0	0.0	no changes		
10	Student 371	0.0	0.2	0.2	1 level		
11	Student 373	0.0	0.0	0.0	no changes		
12	Student 383	0.0	0.2	0.2	1 level		
13	Student 41	0.0	0.2	0.2	1 level		
14	Student 48	0.0	0.2	0.2	1 level		
15	Student 66	0.0	0.2	0.2	1 level		
16	Student 73	0.0	0.2	0.2	1 level		
17	Student 89	0.0	0.5	0.5	2 level		
18	Student276	0.0	0.2	0.2	1 level		
19	Student277	0.0	0.2	0.2	1 level		
20	Student282ab	0.0					




Суралцахуйн явцын мэдээллийг харуулсан хүснэгт

№	Student Name	WSS	SL	Rep	Mic	Head	SR-A	SR %
1	Student 181	11.8	1.2	6964	3863	3842	1019	76%
2	Student 61	11.1	1.0	4678	3734	3710	877	65%
3	Student 192	10.9	1.5	22353	11123	11123	5446	79%
4	Student 201	10.6	1.0	5166	4755	4752	1132	69%
5	Student 57	10.1	1.0	3958	2242	2196	595	68%
6	Student 194	9.1	1.5	26372	13185	13185	5433	72%
7	Student 325	8.1	1.0	8246	5719	5856	2518	68%
8	Student 50	7.6	1.2	6315	3347	3310	2087	58%
9	Student 152	7.2	1.0	2245	3963	3952	462	59%
10	Student 275	7.1	1.0	10009	4307	4244	1612	50%
11	Student 318	6.9	1.0	6273	3223	3204	675	60%
12	Student 127	6.2	1.0	9695	4544	4510	991	65%
13	Student 119	6.1	1.0	7764	3084	3076	1210	64%
14	Student 103	5.9	1.0	5190	3377	3379	419	70%
15	Student 37	5.8	1.0	3815	2917	2905	438	62%
16	Student 260	5.3	1.0	4266	1674	1658	527	41%
17	Student 82	5.1	1.0	2741	1880	1840	488	60%
18	Student 180	4.7	1.0	3990	1737	1723	622	49%
19	Student 349	4.1	1.0	3788	1852	1773	404	20%
20	Student 136	3.7	1.0	6448	2080	2081	364	53%

Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд эерэг болон сөрөг тал хоёулаа ажиглагдав. Үүнд:

- Өөрийгөө хэрхэн хичээллэж байгааг хянаж чадаж байна.
- Компьютерт суурилсан сургалтаар оюутнуудын сонсох чадвар илт сайжирч, тэдний дуудлага, аялга зэрэг нь унаган англи хэлтэй хүмүүстэй адил төстэй болж, урт өгүүлбэрийн үг бүрийг зөв өргөлттэй уншиж байна.
- Сонсох чадвартай уялдан үгсийн сан, ярих, унших, бичих чадвар сайжирч байгаа нь харагдаж байна.
- Үүний зэрэгцээ сөрөг тал мөн ажиглагдаж байна. Үүнд:
- Ажиглалт болон асуулгаар зарим оюутан өөрсдийн хүрье гэсэн түвшинд хүрч суралцаж чадахгүй байна. Хэдийгээр оюутнууд янз бүрийн хурдтай суралцаж байгаа ч, зарим суралцагч мэдэгдэхүйц ахиц гаргахгүй, тэдний WSS буюу одоогийн суралцаж байгаа түвшнийг илэрхийлдэг оноо хасах (-) байна.
- Ийм оюутнуудын ихэнх нь шалгалтад тэнцэхгүй байгаа нь хичээлийн явцад дасгалын зааврыг сайн ойлгохгүй, явцын асуултад ойлгож хариулж чадахгүй байгаа зэрэгтэй холбоотой байна.



Зураг 1

- Зарим оюутан гэртээ интернет, компьютер байхгүйгээс зөвхөн хичээлийн цагаас бусад үед хичээлээ давтаж чадахгүй байна.

Хэлцэмж: Сургалтын эерэг, сөрөг талын тухай хэлэлцэхийн зэрэгцээ хэлний чадварыг эзэмших нь суралцахууд чухал үүрэг гүйцэтгэдэг тархин дахь санах ойтой хэрхэн холбогддогийг энэ диаграммаас харж болно.

Knowles (2004) хэл сурахын талаар тайлбарлахдаа хамгийн гол түлхүүр нь тархинд байгаа харааны, сонсголын, авиа зүйн бүхий л үйлдлийг олон удаагийн давтамжтайгаар хийх нь сонсгол болон унших чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй юм гэжээ.

ДҮГНЭЛТ

DynEd хөтөлбөрөөр хичээллэж байгаа Багшийн сургуулийн 1-р курсийн 78 оюутны дунд явуулсан судалгаа нь компьютерт суурилсан сургалт ба танхимын сургалтын ялгааг гаргах, хэлний чадварыг хөгжүүлэхэд тэдгээр нь хэрхэн нөлөөлж буйг харуулахыг зорьсон судалгаа байлаа. Судалгааны үр дүн хосолмол сургалтын арга нь хэлний 4 чадварыг хөгжүүлэхэд илүү үр дүнтэй гэдгийг үзүүлсэнээс гадна компьютерт суурилсан сургалт нь зөвхөн сонсох чадварыг сайжруулаад зогсохгүй ярих, унших, бичих чадвартай шүтэлцэж болохыг харуулж байна.

Энэхүү судалгаанд мультимедиа болон CALL (компьютер дээр суурилсан хэл сурахуй) –нь дэвшилтэт тал ихтэй. Тиймээс танхимын сургалттай хослуулах нь гадаад хэл сурахад үр дүнтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Feldman, Jacob. (2003). The Simplicity Principle in Human Concept Learning. *Current Directions in Psychological Science*, 227-232.

Knowles, Lance. (2004). The Evolution of CALL. *Journal of Communication & Education*, 108

Hebb, Donald. (1949). *The Organization of Behavior*. Wiley

Pinker, Steven. (1997). *How the Mind Works*. New York: W.W. Norton & Company.